

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Хэрэглэгчийн үнэлгээ

2024 ОН

Хүнс, хөдөө аж ахуйн газрын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа


Дундговь аймгийн ХХААГазар нь тус байгууллагаас иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмж, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлага малид иргэдэд тулгамдаж буй асуудал, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийн цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөх, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор дээрх судалгааг хийлээ. Судалгаанд нийт 15 сумын 180 иргэд малчдыг хамруулсан.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

1. Насны ангиллаар нь харвал:


Дээрх судалгаанд нийт 181 хүн оролцсон байна. Судалгаанд оролцогчдыг насны ангиллаар нь авч үзвэл 18-30 насны 16 %, 31-40 насны 28,7 %, 41-50 насны 28,2 %, 51-60 насны 18,8 % 60-аас дээш 8,3 хувийг эзэлж байна. Судалгаанаас харахад тус байгууллагаар үйлчлүүлэгчид нас насны хүмүүс үйлчилгэ авч байгаа нь харагдаж байна.

1. Таны нас
181 responses



2. Судалгаанд 181 хүн оролцож 55,8 хувийг эрэгтэй, 44,2 хувьд эмэгтэйчүүд оролцсон байна.

2. Хүйс
181 responses




3. Боловсролын төвшингөөр нь авч үзвэл:

Бакалавр 22,1%, бүрэн дунд боловсролтой оролцогч 27.6% , техникийн болон тусгай мэргэжлийн 9,9%, бүрэн бус дунд боловсролтой 27,6 %, бага боловсролтой 1,7 хувь эзэлж байна. Нийт оролцогчийн 22,1 хувь нь дээд боловсролтой байна.

3.Таны боловсрол


181 responses



4. Нийт оролцогчийн 70,4 хувь нь малчин, Төрийн байгууллагад ажилладаг 15,1 хувь хувийн хэвшил-8,4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, төрийн бус байгууллага, ажил хөдөлмөр эрхлээгүй, бусад гэсэн ангиллын хүмүүс 6,1хувийг эзэлж байна. Хөдөө аж ахуйн салбар тэр дундаас малчид нийт оролцогчийн 50 аас дээш хувийг эзэлж байг тус салбарын гол үйлчилгээ авдаг иргэд хамрагдсан байна.

4. Таны ажил эрхэлдэг салбар


179 responses



Аймгийн хэмжээний нийт 15 сумаас Гурвансайхан сум малчид иргэдийг идэвхи санаачилгатай сайн хамруулан ажилласан. Дэлгэрхангай сум хангалтгүй ажилласан нь судалгаанаас харагдаж байна.

5. Та аль сумын иргэн бэ?

181 responses



5. Хамрагдсан малчид, иргэдийн 25,1 хувь нь ЖДҮХоршооны чиглэлээр, Төрөөс олгож буй урамшууллын талаар 16 хувь, Мал үржлийн чиглэлээр 11,4 хувь нь бусад чиглэлээр 24,6 хувь, бэлчээр худаг усны чиглэлээр 15,4 хувь, хүнсний аюулгүй байдал, газар тариалангийн чиглэлээр- 7,5 хувь нь үйлчилгээ авсан байна.

6. Та манай байгууллагаас ямар үйлчилгээ авч байсан бэ?


175 responses



Нийт оролцогчийн 55,7 хувь нь өөрийн биеэр, 14,9 хувь нь цахим хэлбэрээр, 29,3 хувь нь бусад хэлбэрээр үйлчилгээ авсан байна. Дүгнэлт хийхэд цаашид цахим үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

7. Та манайхаас ямар хэлбэрээр үйлчилгээ авсан бэ?

174 responses




Нийт оролцогчийн 31,6 хувь нь 30 хоногийн дотор, 23,4 хувь нь 7-14 хоногийн дотор, 22,2 хувь нь 1-7 хоногийн дотор, 22,8 хувь нь шийдвэрлүүлж чадаагүй байна.

Эндээс дүгнэ үзэхэд ямар асуудлуудад хугацаа их орж байна. Ямар асуудлуудыг шийдвэрлэгдээгүй байна гэдэгт дүгнэлт хийж, цаашид анхаарч ажиллах хэрэгтэй байна.

8. Та манай байгууллагаас үйлчилгээ авах хүсэлт гаргаад ямар хугацаанд шийдвэрлүүлсэн бэ?

171 responses




Тухайн байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй байдал болбоотой бүлэг асуултыг малчид, иргэдийн 35,8 хувь нь хэвийн буюу 80-89 хувьтай, 19,6 хувь нь дунд зэрэг буюу 70-79 хувьтай, 17,9 хувь нь 90-100 хувь үнэлгээтэй буюу маш сайн, 10,6 хувь нь 60-69 хувь буюу тааруу, 16,2 хувь нь муу буюу 60-аас доош хувийн хангалтгүй гэж үнэлсэн байна. Цаашид мэдээллийн ил тод байдал, байгууллагын цахим сайтад байршуулж ажлаа сайжруулах шаардлага гарч байна.

9. Та Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдалд /цахим/ үнэлгээ өгнө үү.

179 responses

ix




Нийт судалгаанд оролцогчдын 37,4 хувь нь facebook цахимаар, 29,6 хувь нь холбогдох албан хаагчдаас, бусад хэлбэрээр, 16,2 хувь нь телевизээр, 12,8 хувь нь бусад хэлбэрээр мэдээлийг авч байна гэж хариулсан.

Нийт оролцогчдын 13,5 хувь нь маш сайн, 55,6 хувь нь сайн, 26,4 хувь нь дунд, 0,9 хувь нь хангалтгүй үнэлэгдсэн нь цаашид үйлчилгээний шуурхай байдалд дүгнэлт хийж ажиллах шаардлагатай харагдаж байна.

11. Албан хаагчдын үйлчилгээний шуурхай байдал, харилцаа хандлага ёс зүйг хэрхэн үнэлэх вэ?


178 responses



Судалгаанд оролцогчийн 14,3 хувь нь маш сайн, 59,4 хувь нь сайн 23,4 хувь нь дунд гэж үнэлсэн байна.

12. Манай байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг хэрхэн үнэлж байна вэ?

175 responses



Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамгийн түрүүнд хийж хэрэгжүүлэх ажлын санал

- Махны үйлдвэртэй болох
- Сумдад мэргэжлийн хүнтэй болох Мэргэжлийн боловсон хүчинтэй болох Зоо техникчтэй болох
- Ногоон тэжээл тариалах
- Өвс тэжээл сайн бэлдэх /Өвс тэжээлний үнэ тогтворжуулах/
- Малын тоо малын чанарыг сайжруулах бэлчээрийн менежментийг сайжруулах
- Мал удам зүйн ажлыг эрчимжүүлэх малчдын хариуцлагыг сайжруулж ажиллах

- Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих
- Малын арьс шир боловсруулах цех
- Малын тоог чанарт анхаарч ажиллах өсвөр хээлтүүлэгч бий болгох
- Ногоон байгууламж цөлжилтийн эсрэг үйл ажиллагаа
- Жимсний аж ахуйг хөгжүүлэх
- Суманд хүнсний хяналтын байцаагчтай болох
- ХАА-н гаралтай түүхий эдийг хаялгүй боловсруулах ААН, иргэн, хоршоог хоршиж ажиллах боломжийг бүрдүүлэх
- Өрхийн аж ахуйг хөгжүүлэх, өвс тэжээлийн хангамжыг нэмэгдүүлэх, бэлчээрийн усан хангамжыг нэмэгдүүлэх, малаа чанаржуулах, МАА-н мэргэжилтний боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, мэргэжилтэнгүүдийг чадваржуулах
- ХАА-н ажилтан малчинтай тулж ажиллах, малчдын дунд ажиллах хэрэгтэй байна.
- Малын тэжээлийн ургамлыг говьд тариалах шаардлагатай байна.
- Махны үнэ муу арьс түүхий эд боловсруулах
- Малын гаралтай түүхий эдийн үнэ муу мөн боловсруулах үйлдвэртэй болох
- Малын үржлийн нэгжийг сум бүрт бий болгох
- ХАА мэргэжлийн боловсон хүчний хангалт
- Малын эмх цэгцгүй эм тарианы хэрэглээнд хяналт тавих
- Малыг чанаржуулах, мах, арьсны үнийг нэмэгдүүлэх
- Гоц халдварт өвчин
- Малын вакцин
- Малын махаа гадагшаа гаргаж эргэлтэнд оруулмаар байна
- Хүнсний бүтээгдэхүүний үнэ өндөр, ашиглалтын хугацаа дууссан байдаг.
- Малын гаралтай бүтээгдэхүүн эргэлтэд оруулах, малын тоо толгойг цөөрүүлж чанарыг сайжруулах
- Хүнсний хадгалалт тал дээр анхаармаар бна
- Малын түүхий эд, урамшуулал
- Уул уурхайгаас үүдсэн хөрсний усны доройтол
- Мах сүү цагаан идээг дэлхийн зах зээлд нийлүүлэх бодлогоор малчдыг хангах
- Арьс шир ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг аймаг бүрт байгуулах нэн шаардлагатай

- Хөдөө аж ахуйн бодлого шийдвэр малчдад чигэлсэн оновчтой үр дүнтэй биш байгаа
- ЖДҮТөсөлт хөтөлбөрийг хүртээмжтэй хэрэгжүүлэх малчдаа дэмжих
- Уул уурхайн зам дагуу нутаглаж байгаа малчид, малын бэлчээрт анхаарал хандуулах шаардлагатай байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ

НЭГТГЭН ТАЙЛАГНАСАНЗАХИРГАА
АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА  Ж.ШИНЭ-УЯНГА